IB DIPLOMA PROGRAMME
PROGRAMME DU DIPLÔME DU BI
PROGRAMA DEL DIPLOMA DEL BI

MONGOLIAN A1 – STANDARD LEVEL – PAPER 1
MONGOL A1 – NIVEAU MOYEN – ÉPREUVE 1
MONGOL A1 – NIVEL MEDIO – PRUEBA 1

Monday 10 May 2004 (afternoon)
Lundi 10 mai 2004 (après-midi)
Lunes 10 de mayo de 2004 (tarde)

1 hour 30 minutes / 1 heure 30 minutes / 1 hora 30 minutos

INSTRUCTIONS TO CANDIDATES

- Do not open this examination paper until instructed to do so.
- Write a commentary on one passage only. It is not compulsory for you to respond directly to the guiding questions provided. However, you may use them if you wish.

INSTRUCTIONS DESTINÉES AUX CANDIDATS

- N'ouvrez pas cette épreuve avant d'y être autorisé(e).
- Rédigez un commentaire sur un seul des passages. Le commentaire ne doit pas nécessairement répondre aux questions d'orientation fournies. Vous pouvez toutefois les utiliser si vous le désirez.

INSTRUCCIONES PARA LOS ALUMNOS

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Escriba un comentario sobre un solo fragmento. No es obligatorio responder directamente a las preguntas que se ofrecen a modo de guía. Sin embargo, puede usarlas si lo desea.

Доорх хоёр зохиолын хэсгийг уншаад, аль нэгийг сонгон, тайлбарлаж бич. Хэрэв шаардлагатай гэж үзвэл зохиолын төгсгөлд буй удирдамж асуултын дагуу бичиж болно.

1.(а)

Тулганд аргалын гал чимээгүйхэн асна. Сэгсүүргэн дээл нөмрөн галын захад суугаа өвгөн гаансаа хаа нэгхэн чимээгүй сорж гал ширтэн бодлогоширно.

Гадаа хотолсон үхэр мал ч анир чимээгүй бөгөөд энэ зуур хөдөлж гарна. Би анир чимээгүйд автан галын тухай бодон сууна.

Ийнхүү анир чимээгүй асдаг гал гагцхүү талын малчин монгол бидэнд л байх агаад энэ галыг шүтэн эцэг өвгөд минь амь зууж, энэ галын дэргэд үр ач нар минь бойжиж, энэ галын дэргэд үлгэр туульс, үүх түүх маань зохиогдсон. Энэ гал бидний үндэс. Энэ гал бидний эх. Галаа тойруулан бид ханаа дугуйлж гэрээ барьдаг. Галаа тойрон сууж орчлонг хүүрнэдэг.

Энэ гал газраас ногоо шиг ургаагүй, тэнгэрээс хур шиг буугаагүй. Өвөг дээдэс минь сэтгэлээсээ цог авч анх ноцоосон юм. Тэр л цагаас хойш гал сэтгэл хоёр амин зүрхний холбоотой болж, сэтгэл хөрөхдөө галаас илч аван бадарч, гал бөхөхдөө сэтгэлээс цог аван ноцдог болсон байнам. Тэр л цагаас хойш монгол хүн галаа харж бадрах, мөхөхийн утгыг таньж, бадрах мөхөхийн уулзвараас орших цагийг олж харсан байнам.

Тулганд гал чимээгүйхэн асаж, үе үе аргалын утаа үнэртэнэ. Галын дөл ширтэн, аргалын утаа үнэртэн суухад илч гэрэл нь биед түгж, огтын аниргүй чимээ нь чихэнд сонстож, агийн ааг арааND амтагдах шиг болно. Тэгмэгц сэтгэл сэрдхийн, аргалын галаас холдож, мартах нь холгүй яваадаа сэтгэл эмзэглэв.

Галаа унтраачих вий гэхдээ манаж хонодог байсан өвөг дээдэс минь намайг өршөө. Өчнөөн зууны турш өчүүхэн ч зуурч бөхөөгүй өвөг дээдсийн минь ариун голомтны улаан гал намайг өршөө.

Тулганы гал цогшин, зэрэглэсэн аргал дуусах дөхжээ. “Өвөө минь, та хажуул даа”. Галдаа аргал нэмж, өнөө шөнө би галаа манаж хоноё.

Галын гэрэл, аргалын утааны нөөлгөнд малын минь хот бүлээн хонох нь мэдээж.

Д.Батбаяр ”Аргалын гал” өгүүллэг. “Айсуй баярын зөн”,1990 номоос

- Энэ зохиолын агуулга, утга санаа юу вэ?
- Гал гэдэг хүний амьдралд хичнээн чухал зүйл болохыг зохиолч хэрхэн дүрсэлсэн бэ?
- “Би” баатрын өгүүлэмж зохиолд ямар үүрэг гүйцэтгэснийг тайлбарла.
- Энэхүү зохиолын хэсгийг уншаад ямар сэтгэгдэл төрсөн тухайгаа бич.

1.(b)

Омог далд сэтгэлд чинь багтаж
Орчлонгоос зовлон дутааж ханилъя
Оюун тэнэгэр ухаанд чинь хөтлөгдөж
Осол цалгараас тоо дутааж ханилъя
Хагарсан шаазан эвлэдэггүйг санаж
Халуун бүлдээ гомдол дутааж ханилъя
Халбага тарганд тогоо сүү ээддэгийг санаж
Хайрлах сэтгэлд чинь хар дутааж ханилъя
Оломгүй далайд бүлүүргүйг санаж
Орь зүрхэндээ цөхрөл дутааж ханилъя
Оройтсон жаргалд ээлтэйг бодож
Олны үгнээс ичгүүр дутааж ханилъя
Үүд хоймор задгай хорвоод
Үхлээс бусад зовлон дутааж ханилъя
Үүрийн цолмон шиг чинийхээ сэтгэлд
Өөрөөсөө бусад хүүхэн дутааж ханилъя.

Б.Энхтуяа "Хайрын шүлэг" ,"Цог"сэтгүүл, 1992/2

- Энэ зохиолын агуулга юу вэ?
- Зохиолын утга санааг зохиолч хэрхэн илэрхийлсэн бэ?
- Зохиолд харьцуулан жиших аргыг хэрхэн хэрэглэснийг тайлбарла.
- Энэхүү зохиолын хэсгийг уншаад ямар сэтгэгдэл төрсөн тухайгаа бич.